



САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорнод аймгийн Цагаан-Овоо сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДОА-2025/005/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn
Чойбалсан хот
2025 он

Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ж.Ганбаатар
Утас: 7056-2112, Цахим хаяг: ganbaatarj@audit.gov.mn
Дорнод аймаг дахь Төрийн аудитын газар
Аудитын менежер: И.Сэмжидмаа
Утас: 7058-4207, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn
Ахлах аудитор: Д.Нармандах
Утас: 7058-4207, Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn
Аудитор С.Төмөрхуяг
Утас: 70584207 Цахим хаяг: Tumurkhuyags@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....	2-3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4-7
5. Аудитын илрүүлэлт	7-8
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....	9

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын дээд байгууллагын Олон Улсын Стандарт
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХХС	Хоршоо хөгжүүлэх сан

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг
Утас:70-56-21-12, Факс: 70-56-21-12
E-mail: khentii@audit.gov.mn

2025.03.24 № 378
танай _____ -ны № _____ -т

ДОРНОД АЙМГИЙН
ЦАГААН-ОВОО СУМЫН ЗАСАГ
ДАРГА Д.БАТМАГНАЙ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Дорнод аймгийн Цагаан-Овоо сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагууд үйл ажиллагаа явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Сумын ИТХ-ын 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 11 дугаартай тогтоолоор сумын 2024 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөг "Хангалттай" гэж дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

232520378

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.ГАНБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	986,480.10	1,623,904.70
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	402,374.80	1,075,351.80
33	АВЛАГА	379,646.70	328,231.00
35	БАРАА МАТЕРИАЛ	204,458.50	220,321.90
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4,718,358.00	6,097,484.00
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,718,358.00	6,097,484.00
39200	Биет хөрөнгө	4,122,231.00	5,539,028.00
39300	Биет бус хөрөнгө	596,127.00	558,456.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	5,704,838.10	7,721,388.80
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	5,704,838.10	7,721,388.80
51	Засгийн газрын хувь оролцоо	5,704,838.10	7,721,388.80
51100	Засгийн газрын оруулсан капитал	1,981,479.30	1,981,479.30
51200	Хуримтлагдсан үр дүн	3,387,079.70	5,403,630.40
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	336,279.00	336,279.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	5,704,838.10	7,721,388.80

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,545,689.10	6,133,617.50
11	ТАТВАРЫН ОРЛОГО	2,393,711.60	3,152,561.30
110	Орлогын албан татвар	1,388,628.80	2,375,996.20
1100	Хувь хүний орлогын албан татвар	1,408,517.90	2,419,562.70
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-19,889.00	-43,566.50
113	Хөрөнгийн албан татвар	612,353.50	416,286.50
118	Бусад татвар, төлбөр, хураамж	392,729.30	360,278.60
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,306,879.60	2,217,379.50
120	Нийтлэг татварын бус орлого	866,879.60	1,912,379.50
121	Хөрөнгийн орлого	0	0
122	Тусламжийн орлого	440,000.00	305,000.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0	0
124	Зээлийн орлого	0	0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	845,097.90	763,676.80
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	5,601,218.40	3,003,340.90
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,601,218.40	3,003,340.90
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,231,363.80	2,688,644.40
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	618,464.10	918,468.40
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	76,233.30	118,472.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	74,619.80	517,996.50
2104	Хангамж, бараа материалын зардал	104,141.30	78,759.90
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	25,942.40	25,797.10
2107	Томилолт, зочны зардал	12,464.00	26,382.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	508,118.00	109,903.80
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	810,681.10	892,864.80
211	ХҮҮ	0	0
212	ТАТААС	0	0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	404,285.10	314,696.50
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0	0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	1,910,040.20	3,130,276.60
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	0	0
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,283,818.40	1,113,725.90
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	626,221.80	2,016,550.70

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,700,918.30	0	4,700,918.30
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,700,918.30	0	4,700,918.30
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	377,698.00	0	377,698.00
9	Тайлант үеийн үр дүн	626,221.80	0	626,221.80
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,704,838.10	0	5,704,838.10
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	5,704,838.10	0	5,704,838.10
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,704,838.10	0	5,704,838.10
19	Тайлант үеийн үр дүн	2,016,550.70	0	2,016,550.70
20	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	7,721,388.80	0	7,721,388.80

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	6,861,125.20	4,498,694.00
11	ТАТВАРЫН ОРЛОГО	2,393,711.60	3,152,561.30
110	Орлогын албан татвар	1,388,628.80	2,375,996.20
1100	Хувь хүний орлогын албан татвар	1,408,517.90	2,419,562.70
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-19,889.00	-43,566.50
113	Хөрөнгийн албан татвар	612,353.50	416,286.50
118	Бусад татвар, төлбөр, хураамж	392,729.30	360,278.60
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	13,952.50	11,431.30
1181	Газрын төлбөр	372,343.80	342,890.70
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	6,433.00	5,956.60
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	656,746.20	582,456.00
120	Нийтлэг татварын бус орлого	216,746.20	277,456.00
122	Тусламжийн орлого	440,000.00	305,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,810,667.40	763,676.80
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,185,952.20	2,454,048.20
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,185,952.20	2,454,048.20
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,816,097.60	2,139,351.70
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	618,464.10	918,468.40
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	76,233.30	118,472.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	74,619.80	611,993.20
2104	Хангамж, бараа материалын зардал	66,508.00	61,266.10
2105	Нормативт зардал	699.8	1,085.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	30,345.00	42,699.40
2107	Томиллот, зочны зардал	12,464.00	26,382.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	511,151.50	15,877.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	425,612.10	343,108.50
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,369,854.60	314,696.50
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	1,675,173.00	2,044,645.80
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	0	0
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	1,793,170.30	1,371,668.80
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,793,170.30	1,371,668.80
2200	Дотоод эх үүсвэрээр	1,793,170.30	1,371,668.80
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-1,793,170.30	-1,371,668.80
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-170,000.00	0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	170,000.00	0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-287,997.30	672,977.00
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	690,372.20	402,374.80
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	402,374.80	1,075,351.80

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,573,795.80	3,666,897.37
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,272,521.00	2,300,858.45
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,229,274.10	1,987,161.96
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	919,814.10	856,212.38
210101	Үндсэн цалин	872,846.60	517,624.34
210102	Нэмэгдэл	-	294,846.21
210104	Урамшуулал	46,967.50	43,741.83
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	114,372.60	106,386.29
210201	Тэтгэврийн даатгал	77,773.90	72,753.45
210202	Тэтгэмжийн даатгал	9,149.70	8,555.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,406.00	6,414.96
210204	Ажилгүйдлийн даатгал	1,830.20	2,044.90
210205	Эрүүл мэндийн даатгал	18,212.80	16,617.98
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	631,124.10	611,993.18
210301	Гэрэл, цахилгаан	51,045.60	42,224.08
210302	Түлш, халаалт	579,878.50	569,569.10
210303	Цэвэр, бохир ус	200.00	200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	41,742.20	37,241.07
210401	Бичиг хэрэг	7,021.80	6,362.70
210402	Тээвэр, шатахуун	19,381.80	18,177.22
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,057.80	2,094.95
210404	Ном, хэвлэл	523.30	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	626.70	626.60
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,130.80	9,979.60
2105	Нормативт зардал	1,401.40	1,085.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,401.40	1,085.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	68,999.90	45,299.31
210601	Багаж, техник, хэрэгсэл	13,503.60	2,599.90
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	661.30	-
210604	Урсгал засвар	54,835.00	42,699.41
2107	Томилолт, зочны зардал	25,949.20	25,863.00
210702	Дотоод албан томилолт	25,949.20	25,863.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	46,764.90	15,877.03
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	44,237.50	15,040.31
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	232.60	-
210803	Даатгалын үйлчилгээ	342.30	314.63
210804	Тээврийн хэрэгслийн татвар	224.10	224.10
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	141.60	120.60
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,409.40	-
210807	Газрын төлбөр	177.40	177.40
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	379,105.70	287,204.70
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	378,552.20	287,204.70
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	553.50	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	43,246.90	313,696.49
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	271,783.50
2132	Бусад урсгал шилжүүлэг	43,246.90	41,912.99
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,047,774.80	1,366,038.92
223001	Бусад хөрөнгө	2,047,774.80	1,366,038.92
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	253,500.00	-
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,573,795.80	4,085,926.95
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,578,565.80	3,666,485.85
320001	Орон нутгийн төсвөөс	2,794,584.90	2,924,291.13
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	783,980.90	742,194.72
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	540,230.00	114,441.09
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	65,000.00	60,110.46
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	106,635.00	54,330.63
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	368,595.00	-
36	ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	455,000.00	305,000.00
360001	Тусламжийн эх үүсвэрээс санхүүжих	455,000.00	305,000.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл□	-	190,814.04
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл□	-	609,843.61

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Тайлангийн үзүүлэлт	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	21,482.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	21,482.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	20,482.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	11,409.0
210104	Урамшуулал	11,409.0
2104	Хангамж, бараа материалын зардал	3,621.8
210402	Тээвэр, шатахуун	3,621.8
2107	Томилолт, зочны зардал	519.0
210702	Дотоод албан томилолт	519.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,932.3
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,932.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,000.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,000.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000.0
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	21,482.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	21,482.0
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	2,240.0
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,000.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	18,242.0
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 435.4 сая төгрөгийн 4 зөрчил¹ илэрснээс, 435.4 сая төгрөгийн 4 зөвлөмж өглөө.

5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. 2024 оны дэвшүүлсэн зорилт, гүйцэтгэл, хүрсэн үр дүнг үнэлж дүгнэсэн эсэх:

Илрүүлэлт:

Цагаан-Овоо сумын эдийн засаг нийгмийг хөгжүүлэх 2024 оны хөгжлийн төлөвлөгөөг 4 бодлого, 13 зорилт, 76 арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталж, биелэлтийг сумын ИТХ-ын 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 11 дүгээр тогтоолоор "Хангалттай" гэж үнэлсэн байна. Аудитаар дүгнэхэд нийт 76 ажлаас 2 ажил огт хийгдээгүй бөгөөд 82.7 хувийн гүйцэтгэлтэй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2-т "Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ" 41.2.7-д "Хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах" гэж заасныг биелүүлж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг хангаж ажиллах.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

2. Орлогын төлөвлөлт, гүйцэтгэл. / малын тоо, толгойн албан татварын төлөвлөгөө, гүйцэтгэл, зарцуулалт нь хууль, журамд нийцсэн эсэх/:

Илрүүлэлт:

Сумын нийт татварын орлогыг 3,066.4 сая төгрөгөөр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 3,186.0 сая төгрөг буюу 119.7 сая төгрөгөөр давж биелсэн байна. Нийт орлого давж биелэхэд 2024 онд цалин хөлс нэмэгдсэнтэй холбоотой цалин, хөдөлмөрийн хөлс, тэдгээртэй адилтгах орлогоос суутгасан татвар 142.1 сая төгрөгөөр, шууд бус орлого 42.6 сая төгрөгөөр, бусад орлого 29.3 сая төгрөгөөр давж биелсэн нь нөлөөлсөн байна. Орлогыг нэр төрлөөр нь авч үзвэл малын тоо толгойн албан татвар 52.5 сая төгрөгөөр, газрын төлбөр 42.5 сая төгрөгөөр, үл хөдлөх хөрөнгийн албан татвар 27.9 сая төгрөгөөр тус тус тасарсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т "Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй", 41 дүгээр зүйлийн 41.2-т "Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ" гэж заасны 41.2.1-т "Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүйтэй холбоотой байна.

Өгсөн зөвлөмж: Орлогыг бүрэн төвлөрүүлж ажиллах.

3. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал:

Илрүүлэлт: Шилэн дансны нэгдсэн цахим хуудсаар мэдээлбэл зохих 190.2 сая төгрөгийн 2 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг цаг хугацаанд нь үнэн зөв байршуулсан байх.

4. Төсөл, арга хэмжээний биелэлт:

Илрүүлэлт:

Сумын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 оны төсвийн жилд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын 579.6 сая төгрөгийн 15 төсөл, арга хэмжээ, хөрөнгө оруулалтын бус 181.2 сая төгрөгийн 19 төсөл, арга хэмжээ, Байгаль хамгаалах сангаас 35.4 сая төгрөгийн 6 төсөл, арга хэмжээг тус тус хэрэгжүүлэхээр баталсан байна. Үүнээс тухайн онд 88.4 сая төгрөгийн 6 төсөл, арга хэмжээг огт хэрэгжүүлээгүй, 1 төсөл, арга хэмжээ 50 хувийн гүйцэтгэлтэй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2-т "Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ", 41.2.7-д "Хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг хангаж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын газарт 2025 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Сумын ТТЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөр төсөл, арга хэмжээний нийт хэрэгжилт 82.7 хувийн гүйцэтгэлтэй байна	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
Малын тоо толгойн албан татвар 52.5 сая төгрөгөөр, газрын төлбөр 42.5 сая төгрөгөөр, үл хөдлөх хөрөнгийн албан татвар 27.9 сая төгрөгөөр тус тус тасарсан байна	1	122.6	-	-	-	-	1	122.6	-	-	-	-
Тайлант онд 88.4 сая төгрөгийн 6 төсөл, арга хэмжээг огт хэрэгжүүлээгүй, 1 төсөл, арга хэмжээ 50 хувийн гүйцэтгэлтэй байна.	1	122.6	-	-	-	-	1	122.6	-	-	-	-
Дүн	3	245.2	-	-	-	-	3	245.2	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Shilendans.gov.mn цахим хуудсанд байршуулах 178 мэдээллээс 2 мэдээллийг хугацаа хоцроож оруулсан байна.	1	190.2	-	-	-	-	1	190.2
Дүн	1	190.2					1	190.2
Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								